



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 08 сарын 21 өдөр

Дугаар A/44

Улаанбаатар хот

Албан тушаалын тодорхойлолтод нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Засгийн газрын 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487 дугаар тогтоол, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” 354 дүгээр тогтоол, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 355 дугаар тогтоол, Газрын дүрмийн 7.1.1, 7.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын бүтэц, чиг үүрэгт өөрчлөлт орсонтой холбогдуулан 2022 оны “Албан тушаалын тодорхойлолт батлах тухай” А/29 дүгээр тушаалын 27 дугаар хавсралтын “нэгжийн нэр” хэсгийн “Хот нийтийн аж ахуйн стандартын хэлтэс” гэснийг “Байгаль орчны стандартын хэлтэс” гэж, 36 дугаар хавсралтын “нэгжийн нэр” хэсгийн “Стандартын хэрэгжилт, хяналтын хэлтэс” гэснийг “Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтэс” гэж, мөн дээрх хавсралтуудын “албан тушаалын ангилал, зэрэглэл” хэсэгт “Дэс түшмэл, Т3-5” гэснийг “Дэс түшмэл, Т3-8” гэж тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-д даалгасугай.

ДАРГА

С.ТӨМӨРДУЛАМ

